| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **16,905,250.2** | **72,520,581.1** | **55,615,330.9** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 51,014.7 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төрийн санд татан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдлийн 2,152,178.3 мянган төгрөгөөр өсөлтөд Эрүүл мэндийн даатгалын сангийн тусламж үйлчилгээний 2,024,429.4 мянган төгрөгийн гүйцэтгэлийн санхүүжилт дутуу, МОН-8 төслөөс 120,389.0 мянган төгрөгийн хөрөнгө тоног төхөөрөмжийг дутуу хүлээн авсан зэрэг голлон нөлөөлсөн байна.

Урьдчилгаа тооцоо дансны үлдэгдэл 519,039.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд байгуулсан худалдан авах гэрээний дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,843,730.3 мянган төгрөгөөр өссөн нь өндөр өртөг бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, эмнэлгийн жижиг багаж хэрэгсэл, бусад хангамжийн материалын нөөц бүрдүүлснээс шалтгаалсан ба үүнээс эм боох, тусгай зориулалтын материалын үлдэгдэл 816,607.2 мянган, сэлбэг, ахуйн материалын үлдэгдэл 110,729.2 мянган бусад хангамжийн материалын үлдэгдэл 2,916,393.8 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 50,087,446.6 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 69,133,925.6 мянган, урсгал төсвийн худалдан авалтаар 87,880.1 мянган, өмнөх оны худалдан авалтын гэрээний дагуу хүлээн авсан хөрөнгийн 404,510.0 мянган, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 176,655.8 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 93,572.8 мянган, акталсан 279,810.2 мянган, элэгдлийн зардал 19,342,141.9 мянган төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдлийн 6,009,820.4 мянган төгрөгийн өсөлтөд эм, эмнэлгийн хэрэгсэл, өндөр өртөгт бараа материал 5,979,694.6 мянган төгрөгийн өглөг гол нөлөө үзүүлсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 49,626,099.1 мянган төгрөгөөр өссөн нь 2019 онд Үндэсний оношилгооны төв ашиглалтад орсноор МОН-8 төслийн хүрээнд нийлүүлсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, алсын зайн оношилгооны мэдээлэл технологийн тоног төхөөрөмжийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/644 дугаар тушаалаар хүлээн авч, 2019-2020 онд ашигласан хугацааны элэгдлийн зардлыг нөхөн тооцсон 5,245,800.5 мянган төгрөг, тайлант оны үр дүн 54,871,899.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус эмнэлгийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 25,283,650.7 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 25,283,650.7 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 888.663.5 мянган, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21,318,338.4 мянган, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 3,076,648.8 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 888.663.5 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18,766,103.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 2,609,547.6 мянган төгрөг, Засгийн газрын тусгай сангаас 1,570,000.0 мянган төгрөг, нийт 23,834,314.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 23,800,105.1 мянган төгрөгийг зарцуулж, 34,219.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны баталсан төсвөөс орлого 1,449,335.8 мянган төгрөгөөр тасарч 94.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь тайлант оны сүүлийн хоёр сард ЭМДС-аас санхүүжилт хийгдээгүй, ЭМДЕГ тусламж үйлчилгээний жилийн эцсийн гүйцэтгэлийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгосноос шалтгаалжээ.

Эмнэлгийн үндсэн ба туслах үйл ажиллагааны төлбөртэй тусламж үйлчилгээний орлого төлөвлөснөөс 467,101.2 мянган төгрөгөөр тасарч, 84.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Коронавируст халдварын улмаас үйлчлүүлэгчдийн тоо болон ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолоор хувь хүнээс төлөх эмчилгээний төлбөрийн тариф тус тус буурсантай холбоотой байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 23,800,105.1 мянган төгрөг буюу 94.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь урсгал зардалд 23,770,825,1 мянган төгрөг, бусад шилжүүлгийн зардалд 29,280.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тайлант онд Коронавируст халдварын улмаас 2021 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 14 хоног хатуу хөл хориог Засгийн газрын тогтоосон, 4 дүгээр сараас Коронавируст халдвар авсан иргэдэд ор дэлгэн ажиллаж байгаатай холбоотой үндсэн тусламж үйлчилгээ буурч, эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо цөөрсөн хэдий ч Үндэсний оношилгоо эмчилгээний төв байгуулагдсанаар зүүн 4 аймаг, Баянзүрх, Налайх, Багануур дүүргүүдийн яаралтай тусламж, мэс заслын үйлчилгээг үзүүлэх болсноор эмчлүүлсэн хүнд өвчтөний тоо нэмэгдсэнээс эм, эмнэлгийн зардал өссөн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 1,992,047.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. *(буцаалт хассан дүнгээр)* Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 13,100.0 мянган төгрөг,
- Дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан хөрөнгө оруулалт 1,819,132.5 мянган төгрөг,
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 159,815.1 мянган төгрөг байна.

Үүнээс цалин, урамшуулалд 1,087,754.1 мянган, хангамжийн бараа материал, эмийн зардалд 80,748.6 мянган, нэг удаагийн тэтгэмжид 813,544.9 мянган төгрөг, нийт 1,982,047.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтын дагуу 4 гишүүн сонгохоос тус эмнэлэг 3 ажилтнаа Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нээлттэй санал хураан сонгон шалгаруулж, баримт материалыг Эрүүл мэндийн яамд хүргүүлсэн боловч Төлөөлөн Удирдах зөвлөл байгуулах шийдвэр гаргаагүй байна.

2021 оны 3 дугаар сараас эрүүл мэндийн даатгал, төсвийн санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 03 дугаар тогтоол гарсантай холбогдуулан санхүүгийн тайланд орлогыг хүлээн зөвшөөрч, тайлагнахдаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу аккруэл сууриар тайлагнахгүй, ЭМДЕГ-аас баталгаажсан санхүүжилтийн дүнгээр буюу мөнгөн сууриар илэрхийлсэн байна. Тухайлбал:

- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын системийн дамжуулалтын алдаанаас шалтгаалан хасагдсан 3,201,914.4 мянган төгрөгийн орлого,
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар тайлант онд тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн тайланг 2021 оны 12 дугаар сарын 10-наар тасалбар болгосноор 2021 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацааны тусламж үйлчилгээний гүйцэтгэл 1,553,424.3 мянган төгрөгийн орлогыг аккурэл сууриар бүртгээгүй байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар тайлант оны сүүлийн саруудын санхүүжилтийг бүрэн олгоогүйгээс 2,024,429.4 мянган төгрөгийн авлага үүссэнээр эм, эмнэлгийн хэрэгслийн 5,979,694.6 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,476,796.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл

нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 943 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус эмнэлэг нь тайлант хугацаанд тайлагнавал зохих 54,131,722.5 мянган төгрөгийн 943 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, хугацаанд нь нийцсэн байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,238,530.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5,083,8 мянган төгрөгийн акт, 1,223,465.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 10,080.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг доорх хүснэгтэд харуулав.

(мянган төгрөг)

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 5,083.8 | 1 | 5,083.8 | - | - | 100 |
| Албан шаардлага | 4 | 1,223,465.8 | 4 | 1,223,465.8 | - | - | 100 |
| Зөвлөмж | 3 | 10,080.6 | 3 | 10,080.6 | - | - | 100 |
| **Нийт дүн** | **8** | **1,238,630.2** | **8** | **1,238,630.2** | **-** | **-** | 100 |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Улсын хоёрдугаар төв эмнэлэг 2019 онд Аксис систем ХХК-ийн Карте программыг эмчилгээ, үйлчилгээний бүртгэлийн системд нэвтрүүлж эхэлсэн байна.

Тус программд хэвтэн эмчлүүлэгчдийн өвчтөний түүхийг бүртгэдэг болсон тул эм, эмнэлгийн хэрэгслийн захиалга эм зүйн албанд шууд мэдээлэгддэг боловч хэлтэс, нэгжүүдийн хоорондын уялдаа муутай байгаагаас шалтгаалан нэг өвчтөнд зарцуулагдаж байгаа эм, эмчилгээнээс гадна хоол хүнс бусад зардлыг бүртгэж тооцоогүй, бүртгэлээр тавих хяналт сул, программын хэрэглээг хянаж, сайжруулах ажил хангалтгүй байгаа тул эрсдэлтэй гэж үзэн дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 14,100,784.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 10,637,214.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 9,894.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,313,085.4 мянга төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 140,590.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан тооцоолоход нийт 68,455.7 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тооцсон,
2. Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн эхний болон эцсийн үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдлээс 10,568,759.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.

### 4.2 Төлбөрийн акт

Нийлүүлэгч компаниас мэдээлэл холбоо, сүлжээний хэрэгслийг худалдан авахаар 2020 оны 10 дугаар сарын 15-нд ХА/16 дугаар гэрээг байгуулж, 9,894.0 мянган төгрөгийг төлсөн боловч одоог хүртэл барааг хүлээн аваагүй, гэрээний хугацаа дууссан байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

### 4.3 Албан шаардлага

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/644 дугаар тушаалын дагуу хүлээн авч, орлогоор бүртгэсэн хөрөнгөөс лавлагаа шатлалын *(Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэгт Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв)*- эмнэлгүүдэд суурилагдсан 9 нэр төрлийн 82 ширхэг 1,443,612.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус эмнэлгүүдтэй тооцоо нийлж, хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй, мөн мэдээллийн системийн алсын зайн оношилгоо тоног төхөөрөмжүүдийг тоолж аваагүйгээс жилийн эцсийн тооллогоор 9 нэр төрлийн 69 ширхэг 120,389.1 мянган төгрөгийн хөрөнгийг Мон-8 төслөөс авлага үүсгэж бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийг комисс томилон хүлээлцэж, тооцоо нийлэн акт үйлдэж, баримтжуулах албан шаардлага өгөх.

Бараа ажил үйлчилгээ худалдан авалтын гэрээнүүдийг он дамжуулан хийснээс хэрэгжилтийг тооцох, дүгнэх боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон, 1,749,083.8 мянган төгрөгийн өндөр өртөгт бараа материал эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээнд заасан нийлүүлэлтийн хуваариас илүү худалдан авалт хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээний нийлүүлэлтийг хуваарийн дагуу эм, эмнэлгийн хэрэгслийг авч байх албан шаардлага өгөх.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 4.4.1 Дотоод хяналтын сул талтай холбоотой асуудал

*Илрүүлэлт*

Санхүүгийн албаны хүний нөөц тогтворгүй, нягтлан бодогч нарын ажил үүргийн хуваарь оновчтой бус, Бодлого төлөвлөлт, салбарын эдийн засгийн шинжилгээ судалгаа, төсөв төлөвлөлтийг төлөвлөлтийн хэлтсээс бүрэн бэлтгэдэггүй, мэдээлэл дутагдалтай, гүйцэтгэх захирлын тушаалын дагуу Санхүү бүртгэлийн албаны дарга /ахлах нягтлан бодогч төлөвлөгөө боловсруулж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд аудитын хяналт шалгалт хийж байгаа нь ашиг сонирхол бий болох эрсдэлтэй байна. Удирдах зөвлөлийн хурлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцсэн тэмдэглэл болон шийдвэрүүд, авсан арга хэмжээний баримт бичиг, архивлалт эмх цэгцгүй зэрэг нь дотоод хяналтын орчин болон үйл ажиллагаа хангалтгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6-д дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмын 3.3. *Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Өгсөн зөвлөмж*

Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, ажил үүргийн хуваарь, ажлын байрны тодорхойлолтыг оновчтой бэлтгэж хэрэгжүүлэх, алба, тасгууд санхүүгийн албанд тухай бүр үнэн зөв, дэлгэрэнгүй тоо мэдээллийг өгч ажиллах.

#### 4.4.2 Авлага данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт*

Тайлант онд хэвтэн эмчлүүлсэн иргэдээс авах (Хамтын төлбөрийн авлага) 10,676.1 мянган төгрөг, Резидент эмч, сувилахуйн сувилагч нарын сургалтын төлбөрийн үлдэгдэл 7,509.4 мянган төгрөг, нийт 18,185.5 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч, авлагаар тайлагнаагүй орхигдуулсан нь Эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар бүлэг 24.4 *Эрүүл мэндийн байгууллага эрүүл мэндийн даатгалгүй иргэнд үзүүлсэн энэ хуулийн 24.6.10-т заасан тусламж, үйлчилгээнээс бусад тусламж, үйлчилгээний төлбөрийг тухайн иргэнээс авна*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 *эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл 26.1 *Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө* гэсэн заалт, иж бүрэн байх, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна

*Өгсөн зөвлөмж*

Хэвтэн эмчлүүлсэн иргэдээс авах хамтын төлбөрийн авлагыг тасаг бүрээр тухайн сард нь бүртгэх, резидент эмч, сувилахуйн сувилагч нарын сургалтын төлбөрийн тайлант онд хамааралттай орлогыг авлагаар бүртгэж тайлагнах.

### 4.4.3 Урьдчилж орсон орлого данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт*

Хувиараа сургалтын төлбөрөө төлдөг Резидент эмч нарын урьдчилж төлсөн сургалтын төлбөр 83,102.8 мянган төгрөгийг тайлант оны орлогоор тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйл 26.1 *Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө* гэсэн заалт, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*

Санхүүгийн тайланг Төсвийн тухай хууль, УСНББОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх, хувиараа сургалтын төлбөрөө төлдөг эмч нарын нийт төлбөрөөс тайлант онд хамааралтай сургалтын орлогыг орлогоор бүртгэж, дараа оны хичээлийн жилд ноогдох сургалтын төлбөрийн орлогыг урьдчилж орсон орлогоор бүртгэж тайлагнах.

### 4.4.4 Цалингийн данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт*

Эмнэлгийн захирлын тушаалаар ажилтнуудын эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг 11-16 хувиар тооцож 39,301.8 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгох журмын 2-т *Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт-д багтсан эрүүл мэндийн ажилтан, эх барих-эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, хүүхэд, нярайн эмч болон сувилагчид тухайн ажил, албан тушаал эрхлэх хугацаанд нь албан тушаалын сарын үндсэн цалингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг сар бүр олгоно*; Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох журмын 3-т *Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно* гэж заасантай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*

Тушаал шийдвэрийн үндэслэлийг холбогдох журамд нийцүүлэн гаргадаг байх, цалин хөлсний нэмэгдлийг журмын дагуу тооцож, Эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл олгох журамд заасан хувь хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулга | | Акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | | | | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | тоо | дүн | Тоо | дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар | | | | | | | | | | | | | | |
| 1 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/644 дугаар тушаалын дагуу хүлээн авч, орлогоор бүртгэсэн хөрөнгөөс лавлагаа шатлалын *(Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэгт Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв)*- эмнэлгүүдэд суурилагдсан 9 нэр төрлийн 82 ширхэг 1,443,612.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус эмнэлгүүдтэй тооцоо нийлж, хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй, мөн мэдээллийн системийн алсын зайн оношилгоо тоног төхөөрөмжүүдийг тоолж аваагүйгээс жилийн эцсийн тооллогоор 9 нэр төрлийн 69 ширхэг 120,389.1 мянган төгрөгийн хөрөнгийг Мон-8 төслөөс авлага үүсгэж бүртгэсэн байна. | Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, жагсаалт үйлдэн хүлээн авч ажиллах. | 1 | 1,564,001.6 | | | | | 1 | 1,564,001.6 | | |
| 2 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Бараа ажил үйлчилгээ худалдан авалтын гэрээнүүдийг он дамжуулан хийснээс хэрэгжилтийг тооцох, дүгнэх боломжгүй нөхцөл | Батлагдсан төсөв болон гэрээний үүргийн биелэлтийг | 1 | 1,749,083.8 | | | | | 1 | 1,749,083.8 | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байдлыг бий болгосон, 1,749,083.8 мянган төгрөгийн өндөр өртөгт бараа материал эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээнд заасан нийлүүлэлтийн хуваариас илүү худалдан авалт хийсэн байна. Энэ нь гэрээний тусгай нөхцөл болон ТБОНӨХБАУХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дах заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудад нийцэхгүй байна. | хэрэгжүүлж авах | | | | | | | | | | |
| 3 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгийн элэгдлийн тооцооллыг давтан тооцоолоход нийт 68,456 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу тайлагнасан байна. | Давтан гаргахгүй байх | 1 | 68,455.7 | 1 | 68,455.7 | | | | | | |
| 4 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийн эхний болон эцсийн үлдэгдэл Санхүү байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн эхний, эцсийн үлдэгдлээс 10,568,759 мянган төгрөгөөр зөрүүтэй (илүү) байна. | Давтан гаргахгүй байх | 1 | 10,568,759.0 | 1 | 10,568,759.0 | | | | | | |
| 5 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Тайлант онд Хэвтэн эмчлүүлсэн иргэдээс авах (Хамтын төлбөрийн авлага) 10,676.1 мянган төгрөг, Резидент эмч, сувилахуйн сувилагч нарын сургалтын төлбөрийн үлдэгдэл 7,509.3 мянган төгрөг нийт 18,185.4 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд орлого, авлагаар тайлагнаагүй орхигдуулсан нь үнэн зөв, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна | Санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн дагуу үнэн зөв тайлагнах | 1 | 18,185.5 | | | | | | | 1 | 18,185.5 |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Эй Эм Жи Констракшн ХХК-иас мэдээлэл холбоо, сүлжээний хэрэгслийг худалдан авахаар 2020 оны 10 дугаар сарын 15-нд ХА/16 дугаар гэрээг байгуулж, 9,894.0 мянган төгрөгийг төлсөн боловч одоог хүртэл барааг хүлээн аваагүй, гэрээний хугацаа дууссан хяналт тавиагүйгээс үргүй зардал гарсан байна. . | Илүү шилжүүлсэн төлбөрийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх | 1 | 9,894.0 | | | 1 | 9,894.0 | | | | |
| 7 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Хувиараа сургалтын төлбөрөө төлдөг Резидент эмч нарын урьдчилж төлсөн сургалтын төлбөр 83,102.6 мянган төгрөгийг тайлант оны орлогоор тайлагнасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлд нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. | Хууль, дүрэм журам стандартыг хэрэгжүүлж ажиллах | 1 | 83,102.8 | | | | | | | 1 | 83,102.8 |
| 8 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ | Эмнэлгийн захирлын тушаалаар эмнэлгийн ажилтнуудын эрүүл мэндийн салбарын хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдлийг 11-16 хувиар тооцож 39,301.8 мянган төгрөгийг илүү олгосон байна. | Журмыг мөрдөж ажиллах | 1 | 39,301.8 | | | | | | | 1 | 39,301.8 |
| Дүн | | | | | 8 | 14,100,784.2 | 2 | 10,637,214.7 | 1 | 9,894.0 | 2 | 3,313,085.4 | 3 | 140,590.1 |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

**АКТ**

2022 оны 02 дугаар сарын 25 № 46/А0150054 Улаанбаатар хот

АХГ-2022/371/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Эй Эм Жи Констракшн ХХК-аас мэдээлэл холбоо, сүлжээний хэрэгслийг худалдан авахаар 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ХА/16 дугаар гэрээг байгуулж, 9,894,000.00 төгрөгийг шилжүүлсэн боловч одоог хүртэл барааг хүлээн аваагүй, гэрээний хугацаа дууссан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж *заасантай нийцэхгүй* байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3 гэж заасныг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Эй Эм Жи Констракшн ХХК-аас мэдээлэл холбоо, сүлжээний хэрэгслийг худалдан авахаар шилжүүлсэн 9,894,000.00 төгрөг *(есөн сая найман зуун ерэн дөрвөн мянган төгрөг)*-ийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэбулган, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч А.Байгалсүрэн нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГҮНЖИДМАА

ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Т.МЯГМАРСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\20220225 Auditin 4 Gazar-46.Docx

001090163

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 251/А0150054 Улаанбаатар хот
АХГ-2022/371/НВ-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн А/644 дугаар тушаалын дагуу хүлээн авч, орлогоор бүртгэсэн хөрөнгөөс лавлагаа шатлалын *Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв* эмнэлгүүдэд суурилуулсан 9 нэр төрлийн 82 ширхэг 1,443,612,553.50 төгрөгийн тоног төхөөрөмжийг тус эмнэлгүүдтэй тооцоо нийлж, хөрөнгө хүлээлцсэн акт үйлдээгүй, мөн мэдээллийн системийн алсын зайн оношилгооны тоног төхөөрөмжүүдийг тоолж, хүлээн аваагүйгээс жилийн эцсийн тооллогоор 9 нэр төрлийн 69 ширхэг 120,389,062.46 төгрөгийн хөрөнгийг МОН-8 төслөөс авлага үүсгэж бүртгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 5.1.2 *"төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх"*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12.1*"Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Лавлагаа шатлалын *Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв)*- эмнэлгүүдэд суурилуулсан дээрх хөрөнгүүдийг нэр төрөл тус бүрээр хөрөнгө хүлээлцсэн акт үйлдэх, хөрөнгийг тоолж хүлээн аваагүй зөрчлийг арилгах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэбулган, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга А.Байгалсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — Г.ГҮНЖИДМАА

ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ /АУДИТОР — Т.МЯГМАРСҮРЭН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 № 249/40150054 Улаанбаатар хот

АХГ-2022/991/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Улсын хоёрдугаар төв эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

**Бараа ажил үйлчилгээ худалдан авалтын гэрээнүүдийг он дамжуулан хийснээс хэрэгжилтийг тооцох, дүгнэх боломжгүй нөхцөл байдлыг бий болгосон, нийт 1,749,083,764.00 төгрөгийн өндөр өртгийн эм, эмнэлгийн хэрэгслийг гэрээнд заасан нийлүүлэлтийн хуваариас илүү худалдан авалт хийсэн байна.**

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4 *"үнэн зөв байх"* Төсвийн тухай хуулийн 6.4.1*"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16.1*"Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна"*, 27.1.3 *"төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх"*, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9.2.10 *"гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг"* гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний нийлүүлэлтийн хуваарь, тоо ширхгээс хэтрүүлэн худалдан авалт хийсэн зөрчлийг давтан гаргахгүй байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллахыг Улсын хоёрдугаар төв эмнэлгийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэбулганд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Г.ГУНЖИДМАА

ДАБЛЬ АКСИОМ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ /АУДИТОР Т.МЯГМАРСҮРЭН

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264250*

0010800807

ТЭМДЭГЛЭЛ

.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................
.............................................................................................................................................................

ТЭМДЭГЛЭЛ